



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2020 он 04 дугаар  
сарын 22 ны өдөр

Дугаар ХЭГ/1062

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН  
ГАЗРЫН ДАРГА З.МЭНДСАЙХАН ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Коронавируст халдварын цар тахалтай тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны хүрээнд анхаарах асуудлын талаар Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийг хавсралтаар хүргүүлж байна.

Зөвлөмжийг өөрийн болон эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллана уу.

Хавсралт: 2 хуудастай.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Л.ОЮУН-ЭРДЭНЭ



МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг.  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2020-04-10 № 01/4291

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Юуны өмнө дэлхий нийтэд тархаад буй коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, хамгаалахад Та бүхэн оновчтой, шуурхай шийдвэр гарган ажиллаж байгаа явдалд талархал илэрхийлье.

Аливаа гамшиг, цар тахлын эсрэг тэмцэхэд зарцуулагдах ёстой хөрөнгийг хэн нэгэн шамшигдуулах нь бусдын зүтгэсэн зүтгэл, хүчин чармайлтыг үр дүнгүй болох, үр дагаврыг нь илүү олон хүн ам нас, эрүүл мэндээрээ төлөх эрсдэлтэй байдгийг авлигатай тэмцэх олон улсын болон үндэсний байгууллагууд, эрдэмтэн, судлаачид онцлон тэмдэглэж байна.

Авлигатай тэмцэх газар нь Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д заасан “авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын талаар зөвлөмж гаргах, байгууллага, иргэний хүсэлтээр түүний үйл ажиллагаан дахь авлигад өртөх боломжийг багасгах талаар заавар, зөвлөгөө өгөх” чиг үүргийг хэрэгжүүлдэг. Энэхүү чиг үүргийнхээ хүрээнд Засгийн газраас коронавируст халдварын цар тахалтай тэмцэх зорилгоор төлөвлөн хэрэгжүүлж буй үйл ажиллагааны хүрээнд дараах асуудалд анхаарлаа хандуулахыг зөвлөмж болгон хүргүүлж байна.

1/. Тендер шалгаруулалтын онцгой журам хэрэглэн эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, тусгаарлах байр болон бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаанд тавих хяналтыг нэмэгдүүлэх, ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг хэрэгжүүлж ажиллахад анхаарах. Энэ талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор тусгай цахим хуудсанд тогтмол байршуулж, олон нийтэд хүргэх;

2/. Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээ болон аливаа хандив, тусламжийн бараа, ажил, үйлчилгээний чанар, стандарт, аюулгүй байдалд онцгойлон анхаарал хандуулах. Бусад улс орнуудын зарим туршлагаас харахад хэт өндөр үнэтэй, эсхүл чанар муутай бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг авлигын замаар худалдан авах, нийлүүлэх тохиолдлууд гарч байна. Түүнчлэн, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хандив авахтай холбогдсон хязгаарлалтыг мөрдөж ажиллах, хандив тусламжийн хөрөнгийн зарцуулалтыг олон нийтэд ил тод, нээлттэй тогтмол мэдээлэх;

3/. Үүсээд буй эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тодорхой сангаас дэмжлэг олгох, эсхүл шимтгэл, татвараас чөлөөлөх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ харгалзан үзэх шалгуур үзүүлэлт, түүнд тавигдах шаардлага,

0005910

шалгаруулах үе шатны талаарх мэдээллийг олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр түгээх, ил тод болгоход анхаарах. Ямар нэгэн байдлаар эрх мэдэл болон мэдээлэлд "ойр" этгээдүүд өөртөө болон өөрийн хамаарал бүхий этгээдэд давуу байдал олгох боломжийг олгохгүй байхаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;


4/. Албан тушаалтан нь өөрийн хамаарал бүхий этгээд болон хувийн ашиг сонирхлын үүднээс тодорхой бараа, бүтээгдэхүүн, эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлчилгээний талаар олон нийтэд шууд болон шууд бус байдлаар санал болгох, сурталчлахаас зайлсхийх. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан сурталчилгаатай холбогдсон хязгаарлалтыг мөрдөж ажиллах;

5/. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт /хэсэгчлэн/ шилжүүлсэн бүс нутагт иргэн, зорчигч тээврийн хөдөлгөөнийг хязгаарласан, эсхүл хилийн боомтыг хаасан, хөдөлгөөнийг хязгаарласан үед хяналт тавин ажиллаж буй албан хаагчдын шийдвэрт бусад албан тушаалтан өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхөөс урьдчилан сэргийлэх, хяналтыг нэмэгдүүлэх. Албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар өөрийн удирдах албан тушаалтан, эсхүл хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэж байх үүргийн хэрэгжилтийг хангуулах;

6/. Нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор аливаа хууль бус үйл ажиллагааны талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлсэн иргэн, төрийн албан хаагчдад зүй бус дарамт шахалт, шийтгэл оногдуулахаас сэргийлэх тодорхой арга хэмжээ авах, энэ талаар олон нийтэд сурталчлах;

7/. Коронавируст халдварын цар тахлын тархалтаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах зорилгоор аливаа албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх зохицуулалтыг чанд хэрэгжүүлэн авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллах зэрэг болно.

ДАРГА, ТЭРГҮҮН КОМИССАР



З.ДАШДАВАА